



**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

20¹⁵ оны 02 сарын 03 өдөр

Дугаар 10

Улаанбаатар

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол улсын Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ТӨХ-той байгуулсан контракт гэрээний 37 дугаар заалтыг удирдлага болгон ТУШААХ нь:

1. Дээрхи хууль, тогтоомж тэдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан журам заавруудыг холбогдох ажилтнуудаар нарийвчлан судлуулж байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж дүнг танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Батболдод даалгасугай.

2. Энэ чиглэлээр СЯ, ЭХЯ, ТӨХ, АТГ зэрэг холбогдох байгууллагуудаас ирүүлсэн удирдамж, заавар, зөвлөмжийн мөрөөр хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнгийн талаар тухай бүр нь хариу мэдэгдэж, хариу шаардсан албан бичиг тоотын хариу өгөлтөд хяналт тавьж ажиллахыг байгууллагын дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Чулуунбаатарт үүрэг болгосугай.

3. Байгууллагын 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 2014 оны тайланг худалдан авах ажиллагааны тухай хуулийн 48, 49-д, 2015-2018 оны "Зорилтын санал"-ыг мөн хуулийн 21(1)-д заасны дагуу гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэхийг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Батболд, ерөнхий ня-богийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүүриймаа нарт даалгасугай.

4. Байгууллагын шилэн дансыг хөтлөлж санхүү, худалдан авалтын талаархи мэдээ мэдээлэлийг хуульд /журамд/ заасан хугацаанд нь цахим хуудсанд байршуулж байхыг ерөнхий ня-богийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүүриймаа, цахим хуудсыг /веб сайтыг/ тогтсон стандартын дагуу шинэчлэн баяжилт хийж ажиллахыг СҮХ-ийн инженер Б.Түвшинтөгс, ил тод байдлын мэдээлэлийн самбарыг хариуцаж ажиллахыг захирлын туслах Т.Ганхүлэг нарт тус тус даалгасугай.

5. Байгууллагын үнэлгээний хороонд орж ажиллах хүмүүсийг сонгож худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх, сертификаттай /АЗ/ сургалтанд хамруулах ажлыг зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Батболдод даалгасугай.

6. Энэ тушаалыг биелэлтэд бүхэлд нь хяналт тавьж ажиллахыг ерөнхий инженер О.Бавуудоржид үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.АЛТАНГЭРЭЛ